| | | бахархал" нэрэмжит аймаг, сум, бүсийн үйл ажиллагаа зохион байгуулах. | шилдэг авьяастанууд тодорсон байх Авьяастаны тоо | | | | төсөв Иргэдийн хандив | | Уяхан замбуу тивийн наран их наадмын хүрээнд соёлын төвийн дэргэдэх 48 хүүхдийн бүрэлдхүүнтэй "Говийн эгшиг" хамтлаг нь "Өв соёлын өлгий-Нутгийн бахархал"сэдэвт төрсөн нутгийнхаа өв соёлын онцлогыг харуулсан зохиомжит шинэ уран бүтээл туурвиж Задгай тетарт тоглогдож үзэгч олонд хүргэн талархал хүлээж ажиллаа.<br>Нутгийн бахархал болсон тэмээний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх өвлөн уламжлуулах, өв соёлын боловсрол олгохоор зорилгоор "Тэмээний өв соёлын танхим байгуулж,Соёлын цаг -14, "Соёлын сэргэлт-2023," "Нутгийн соёл танаас эхлэнэ" соёлын давалгаа үйл ажиллагааны хүрээнд нутгийн онцлог, бахархал болсон Угсаатны зүй, ашигт малтмал, шашны эд зүйл, байнгын 3 сэдвээр үзэсгэлэн гаргаж нийт 214 хүүхэд 383 том хүнд хүргэж ажиллаа.Бүгд давхардсан тоогоор 597 иргэдэд хүрч ажиллаа. Нүүдэлчин монгол 2023 дэлхийн фестиваль наадамд аймгийнхаа баг бүрэлдхүүнд өвлөн уламжлагч Т.Мөнхцэцэг оролцож Дуу хуурөв соёлын өлгий нутгийнхаа өв соёлыг 21 аймаг, 9 дүүрэг сурталчлан баг хамт олноороо амжиттай оролцлоо.<br>МУ-ын аварга малчин агсан Т.Лувсанбалдангийн нэрэмжит Тэмээний өв соёл-Тэмээчдын баяр-2023 нь Улсын аварга малчин Т.Лувсанбалдангийн үр хүүхдүүд ивээн тэтгэж баярын үйл ажиллагаа өргөн цар хүрээтэй зохион байгуулагдаж, нутгийн бахархал тэмээний өв соёл, онцлох ажлаараа МОНЦАМЭ Улс, аймгийн хэмээнд сурталчлагдлаа. Шилдэг авьяастаны тоо 68 . | |
| Зорилго2.3.3 Хүн амын боловсрол, соёл мэдээлэл, соёл чөлөөт цагийн эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн номын сан, ном зүйн үйлчилгээг үзүүлж, Хүүхэд залуучуудыг номтой нөхөрлүүлэх, эерэг хандлага, дадлыг бий болгон, бие хүнийг бүтээлчээр хөгжүүлэхэд оршино. | | | | | | | | | | |
| Зорилт | 2.3.3.1 | Номын сангийн байнгын уншигч 536 байсныг 2024 онд 877, олговол | Байнгын уншигч-олговол зохих номын | тоо | 536<br>486<br>90 | 752<br>870<br>90 | төсөв шаардахгүй | | Номын сан нь урьд оныхоос байнгын уншигчийн тоог 216 -аар нэмэгдүүлж -752 болгон, Олговол зохих номын тоо 870, | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зохих номын тоо 2020 онд 870 байсныг 2024 онд 3480, шинэ уншигч 2020 онд 86 байсныг 2024 онд 344 болгон нэмэгдүүлнэ. | тоо шинэ уншигч тоо | | | | | | Шинээр уншигчийн тоо 24 уншигч нэмэгдэж нийт 101 уншигчтай боллоо. | |
| Арга хэмжээ | 2.3.3.2 | Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргах. | Гаргасан үзэсгэлэнгийн тоо | тоо | 15 | 17 | | | Төрт ёс хаадын сан, Бүсгүй, Номтой нөхөрлөе, Бидний бахархал эр цэрэг, Эрүүл мэнд эрхэм баян,гэр бүлийн багц гээд нийт сэдэвчилсэн үзэсгэлэн 13, Шинэ номын үзэсгэлэн -2, нийт 18 үзэсгэлэн гаргаж 443 номыг танхимаар болон цахимаар сурталчлан ажиллахад танхимаар 236 хүн үзэж, цахимаар 1658 хүн хандалт хийсэн байна | 100% |
| | 2.3.3.3 | Номын баяр, уншигчдын бага хурал, уулзалт арга хэмжээг зохион байгуулах. | арга хэмжээ зохион байгуулсан байх | тоо | 5 | 5 | 100 000 | жилдээ | МАЗЭШХ-ны хэлтсийн ном зүйч Т.Наранчимэг “Номтой нөхөрлье” ном унших ач тусын талаар уулзалт ярилцлага зохион байгуулж нийт 86 уншигч хүүхэд хамрагдаж мэдээлэл авлаа. НОМЫН БАЯР-2023 ИЛҮҮ ИХ УНШЪЯ”уриатай 34 дэх удаагийн номын баяраар “Миний монгол бичиг - 2023 сайхан бичигтэн” уралдаан, Түргэн хэллэг, Алтан хонх,Ном хож танин мэдэхүйн тэмцээн гэх мэт нийт 5 үйл ажиллагаа зохион байгуулахад 236 уншигч хүүхдэд хамрагдаж 15 хүүхдийг шагнаж урамшуулан ажиллаа.Шинээр 75 уншигч карт нээлгэлээ. | 100% |
| | 2.3.3.4 | “Олуулаа ном уншицгаая” Иргэдийг номтой нөхөрлүүлэх аян зохион байгуулах. | аян өрнүүлэн ажилласан байн | тоо | 1 | 2 | 50 000 | жилдээ | “Олуулаа ном уншицгаая”, “Иргэдийг номтой нөхөрлүүлэе” 14 хоногийн аяныг 2 удаа зохион байгуулж нийт давхардсан тоогоор 136 уншигч хамрагдаж, дуудлагын үйлчилгээнд 15 уншигч, зөөврийн үйлчилгээнд 25 ахмад нийт 35 уншигч хамрагдан үйлчлүүллээ. Дундговь аймгийн төв номын сантай хамтран ном солилцооны гэрээгээр “Гэрээр ном олгох танхимаас ном солилцоогоор шинэ 20 ном авч 35 уншигчдад хүргэж, шинээр 35 уншигч карт нээлгэлээ.Сургуулийн номын санчтай | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хамтран ”ӨСВӨРИЙН ЯРУУ НАЙРАГЧ” уралдааныг зохион байгуулж нийт 25 яруу найраг сонирхогч хүүхдүүд ур чадвараа сорин оролцлоо. | |
| | 2.3.3.5 | Номын сангийн фонд бүрдүүлэлтийг сайжруулах, жил бүр шинэ номоор баяжуулах. | фонд баяжилтын номын тоо | тоо | 70 | 97 | Байгууллага төсөв хандив | жилдээ | Сумын хэмжээнд нийт уншигчдынхаа дунд “Нэг ном -нэг хүүхэд” 21 хоногийн аян өрнүүлэн ажилласны үр дүнд хандиваар 100 ном хандиваар цуглуулаж шинэ номоор фондоо баяжуулан ажиллаа | 100% |
| | 2.3.3.6 | 14.1.5 “Танд ойрхон номын сан“ зуныг номтой өнгөрүүлэх аяныг зохион байгуулах. | аян өрнүүлэн ажилласан байх | тоо | 1 | 1 | Улсын төсөв хандив | жилдээ | Сургуулийн хүүхдүүдийн дунд “Танд ойрхон номын сан” үйлчилгээг 118 уншигчдад хүргэлээ. Аяны хүрээнд уншигч хүүхдүүдийн ном уншиж тэмдэглэсэн бүтээл үзэсгэлэн гаргаж, идэвхи санаачлагатай уншигч 6 шалгаруулж шагнаж урамшуулав. | 100% |
| | 2.3.3.7 | Мөрөөдлийн самбараа хамтдаа бүтээцгээе, болон ширээний театр уралдааныг тус тус зохион байгуулах. Гэрээр “Номын богц” аялуулж, эцэг эхчүүд хүүхэдтэйгээ хамтран ном унших дадлыг хэвшүүлэх | гэр бүлээр ном уншигчийн тоо | тоо | 2 | 2 | Улсын төсөв хандив | 2-3 улирал | Дундговь аймгийн төв номын сантай хамтран ном солилцооны гэрээгээр “Гэрээр ном олгох танхимаас ном солилцоогоор шинэ 20 ном авч “Гэрээр номын богц аялуулах үйл ажиллагааг 2 удаа “Шидэт номын богц” нэртэйгээр 3 төрлийн номын богцыг аялууллаа. Тус ажиллагаанд 15 гэр бүл, зорилтот бүлгийн -16 хүн, дуудлагын үйлчилгээнд 25 нийт 56 уншигчдад хамрагдав. Мөрөөдлийн самбараа хамтдаа бүтээцгээе "Ширээний театрт урлан бүтээх уралдаанд СӨБ-ын Ахлах болон Бэлтгэл бүлэг, 1-5 ангийн дунд зохион байгуулагдаж нийт-15 бүтээл оролцоо.Уралдаанд оролцсон хүүхдүүд нь гарын доори материалыг ашиглан өөрийн уншсан номынхоо Гурван тоорой үлгэр, Манжин, Ноён талхын үсчний газар, Ойн амьтад, Долоон өндөгтэй доголон шаазгай, Эвтэй дөрвөн амьтан гэх мэт 15төрлийн үлгэрийн баатар ширээний театртаа үлгэрийн баатруудаа сэтгэн бодож урлаж хийсэн нь хүүхдүүдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлсэн бүтээлч ажил болоо. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.3.3.8 | Уншигчдын дунд "Тойрон аялал үлгэрийн баатрууд танай ангиар зочлох нь" аяныг зохион байгуулах. | аяны тоо | тоо | 1 | 1 | Улсын төсөв хандив | 2-р улирал | “Соёлын сэргэлт-2023” аяны үйл ажиллагааны хүрээнд Монгол улсын хүүхэлдэйн театрын шинэ уран бүтээл О.Сундуйн зохиол “Хүүхэлдэйн чинээ ээж” хүүхэлдэйн жүжгийг тоглолт үзэгч олондоо хүргэн ажиллаа.<br>Номын сангийн Оюунлаг тархи клуб ын сурагчид нь “Үлгэрийн баатар танай ангиар зочилсон нь" аялан тоглолтыг Цэцэрлэгийн ахлах, бэлтгэл, бага ангиудаар Орос ардын “Өнхрүүш”үлгэрээр дүрийн тоглолт хийж цэцэрлэгийн ахлах бэлтгэл, дунд 4 бүлгээр аялаж 58 бяцхан үзэгчдэд хүргэн ажиллаа.<br>Соёлын бүтээлч” сар аяны хүрээнд “Мөнх тунх” хүүхэлдэйн киног нүүдлийн үйлчилгээгээр Цэцэрлэгийн 4 бүлгийн нийт 65 баяцхан үзэгчдэд хүргэн ажиллаа. | 90% |
| **Зорилго: 2.3.4.** Сумын нутаг дэвсгэрт байгаа соёлын биет болон биет бус өвийг олж илрүүлэх, судлах, бүртгэн баримтжуулах, хадгалж хамгаалах, өвлүүлэн уламжлуулах, гадаад, дотоодод түгээн дэлгэрүүлэх. | | | | | | | | | | |
| Зорилт | 2.3.4.1 | Уламжлалт өв соёлоос суралцах, өвлүүлэн үлдээх, хөгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ. | Зохион байгуулсан ажлын тоо | тоо | 8 | 8 | | | **Тэмээний өв соёлын танхим, дугуйлан сургалтууд, Тэмээ тэнгэрлэг амьтан, Амар байна уу гар зургийн уралдаан, Таван эрдэнэ тэмцээн, Үндэсний бичиг соёлын баяр ,Миний монгол бичиг, Өв соёл танин мэдэхүйн АХА тэмцээн,Угийн бичигтэн удамынхан уралдаан , Алтан хэлхээ 3 үеийн уулзалт, гээд 15 ажлыг зохион байгуулж Уламжлалт өв соёлоос суралцах, өвлүүлэх, хөгжүүлэх орчин нөхцлийг бүрдүүллээ.** | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээ | 2.3.4. 2 | Соёлын биет бус өвийг бүртгэн баримтжуулах аяныг өрнүүлэх | БМС баяжилтын тоо | тоо | 5 | 8 | 50 000 | | Эх хэл, бичиг соёл, хөдөлмөр, зан үйл, заншил, зан үйл, баяр ёслол, Уламжлалт гар урлал гэсэн чиглэлээр 4 чиглэлээр 8 өвлөн уламжлагч нарыг илрүүлэн журмын дагуу бүртгэн баримжуулалтын ажлыг хийж сандаа баяжилт хийлээ. | 100% |
| | 2.3.4. 3 | 15.1.6 Соёлын биет бус өвийн гар урлалын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах. | Үзэсгэлэн уралаанд оролцсон урчуудын тоо | тоо | 16 | 40 | 150 000 | | Сумынхаа ЗДТГ болон Ахмадын холбоотой хамтран “Өндөршил түншлэл-2023” сүү, цагаан идээний үзэсгэлэн худалдаа, “Өв соёлын өлгий нутгийн урчууд» сэдэвт үзэсгэлэн худалдааг 2 удаа зохион байгуулж нийт 60 өвлөн уламжлагчийн 135 бүтээл оролцож 26 бүтээл шалгарч шагнагдлаа. Өвлөн уламжлагч нар нь цагаан идээгээ ашиглан квас, молоко, бялуу, чихэр, ирис, цэлцэгнүүр, үзэмтэй луувантай ээдэм зэрэг шинэлэг бүтээгдэхүүнийг хийснээрээ үзэсгэлэнгийн онцлох ажил байлаа. | 100% |
| | 2.3.4. 4. | “Өв соёл” цуврал танин цахим мэдээлэл болон мэдэхүйн төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах. | Арга хэмжээний тоо | тоо | 60 | 10 | 50 000 | | Өв соёл” цуврал танин мэдэхүйн “Цахим орчин соёл түгээе” ардын ёс заншил, өв уламжлал, танин мэдэхгүй 5 төрлийн 136 мэдээлэлийг цахимд байршуулж, Өв соёл АХА танин мэдэхүйн тэмцээн, Бичиг соёлын баяр, Номын баяр, Тэмээний өв соёл боловсрол, Би монгол хүн шүлэг, Ураг удмынхан ургийн бичгийн уралдаан гэх 15 үйл ажиллагаа зохион байгуулж нийт 456 хүн хамрагдлаа. | 100% |
| | 2.3.4. 5. | 15.1.8 Орон нутгийн иргэдийн түүх соёл, танин мэдэхүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор жил бүр үзэсгэлэн гаргах. | үзэсгэлэнгийн тоо | тоо | 0 | 5 | зардал шаардах гүй | | ЗДТГ болон Ахмадын холбоотой хамтран Өндөршил түншлэл-2023 сүү, цагаан идээний үзэсгэлэн худалдаа, “Өв соёлын өлгий нутгийн урчууд» сэдэвт үзэсгэлэн худалдаа, Нээлттэй хаалганы өдөрлөгөөр “Угсаатны зүй, Ашигт малтмал””Шашны эд зүйл”, Соёлын сэргэлт -2023 аяны хүрээнд бүтээлч үйлдвэрлэл гар урлалын гэх мэт 6 үзэсгэлэнгүүд дэлгэн үзүүлж 214 хүүхэд, насанд хүрэгсэд | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 284,нийт давхардсан тоогоор 498 үзэгчдэд үйлчилж нутгийн өвлөн уламжлагчдын урлал, байгалийн баялаг, угсаатан зүй,шашны эд зүйлээ таниулж сургалчилж иргэдийнхээ өв соёл, танин мэдэхүйн боловсролыг дээшлүүлэн ажиллаа. | |
| | 2.3.4.6 | Хүүхэд залуучуудын дунд “Эх нутаг–өв соёл” сэдэвт түүх соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газраар танин мэдэхүйн аялал зохион байгуулах | аялал зохион байгуулсан байх | тоо | 1 | 2 | 50 000 | | Сумын ЗДТГ болон ЕБС-тай хамтран Эх нутаг өв соёл сэдэвт танин мэдэхүйн аялалаар Их нартын хадны байгалийн цогцолборын Луугарын тойром , Элс дэл, Сэнжит хад, Улаа хадын ам, Бургасны ам болон их нартын хаданд байрлах байгаль хамгаалах кемптийн үйл ажиллагаатай танилцуулж ургамал амьтдын эргэх холбоо тэдгээрийн ач тус байгаль дэлхий ан амьтнаа хайрлан хамгаалах тухай ан амьтад төрөл зүйлийн шувуудын нүүдэл амьдрах орчны талаар мэдлэг мэдээлэлийг хүүхдүүдэд олголоо. Мөн тэнд нүүдэлчин соёлын өв уламжлалыг харуулсан сархинаган тоонотой гэр болон эдлэл хэрэглэл гар урлалтай танилцлаа. Аялалд 6-9 ангийн нийт 20 хүүхэд хамрагдав | 100% |
| **Зорилго: 2.3.5.**Угийн бичиг хөтлөх аргачлал, ач холбогдлыг таниулан, удмын түүхээрээ бахархах, удам дамжин өвлүүлж уламжлуулах, угийн бичгийг программыг нэвтрүүлэх. | | | | | | | | | | |
| Зорилт | 2.3.5.1 | 2020 онд сумын нийт 463 өрхийн 41 хувь нь угийн бичиг хөтөлж байсныг 2024 онд 50 хувьд хүргэнэ. | Угийн бичиг хөтөлсөн өрхийн эзлэх хувь | хувь | 42,8 | 45% | төсөв шаардах гүй | | Сумын нийт 470 өрхийн 245 өрх угийн бичигтэй болж 52.1 хувьд хүрч, хагас жилээс 5,3 хувь өссөн байна | 100% |
| Арга хэмжээ | 2.3.5.2 | Иргэдийн дунд угийн бичгээ хөтлөх хөдөлгөөн өрнүүлж, уулзалт, | Уулзалт үйл ажиллагаа зохион байгуулсан | тоо | 2 | 3 | 50 000 | | Сумын хэмжээнд Сургуулийн анхны төгсөгч Довчиндорж гуайн санаачилгаар Цээнхорол, Цэрэндэжид, Лхамжий нарын үр сад, Надмидынханы гээд 2 | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйл ажиллагаа зохион байгуулах. | тоо - | | | | | | удмынхан “Угийн уулзалт баяраа хийж нийт 160 өрхийн 670 орчим ахан дүүс төрөл төрөгсөд хамрагдсан байна. Иргэдийн дунд угийн бичгийн гар авлага поршур 150 хүнд хүргэж, цахимд сургалт ын мэдээлэлийг 2 удаа байршуулж ажиллахад цахимаар 145 хүн хандалт хийсэн байна. Зохион байгуулсан ажлын тоо -2 | |
| | 2.3.5.3 | Айл өрхийн ургийн бичгийг цахим программд шилжүүлэх ажлыг эхлүүлэх. | Цахим программд шилжүүлэх ажлыг эхлүүлэх. | тоо | 0 | 5 | Хандив | | Айл өрх нь ургийн бичгийн программыг хэрхэн яаж ашиглах вэ, ач холбогдол, үр дүн мэдээлэл-5, яамнаас гаргасан контент мэдээлэл 3-ыг тус тус байршуулж цахимаар сурталчлан ажиллаа.Орчин үеийн техник, технологид суурилсан программ хангамжийн тусламжтайгаар шийдвэрлэж хүн бүр угийн бичгээ хөтөлж, өөрийн болон удмын түүхээ бичиж сурахыг уриалж ажилласнаар 2 өрх, 200 000 төгрөний үнэтэй программыг авч угийн бичгийг хөтлөж цахим программд шилжүүлэх эхлэл суурь тавигдлаа. | 50% |
| 2.4 Хөдөлмөр, нийгмийн хамгаалал | | | | | | | | | | |
| Зорилго: 1.Хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх, төсөл хөтөлбөрт хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлэх. | | | | | | | | | | |
| Зорилт | .2.4.1 | 2020 онд түр ажлын байр 10 байсныг 2024 онд 40, байнгын ажлын байр 2020 онд 10 байсныг 2024 онд 30-д хүргэнэ | Түр ажлын байрын тоо Байнгын ажлын байрын тоо | Тоо | 60<br>10 | 60<br>15 | ХЭДС | 1-3-р улиралд | 2023 оны 11 сарын байдлаар байнгын ажлын байраар 15 иргэн, түр ажлын байраар 46 иргэн тус тус хамрагдсан. | 90% |
| Арга хэмжээ | 2.4.1.1 | Төсөл хөтөлбөрт иргэд хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх. | Төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо | Тоо | 0 | 3 | 41,2 сая ХЭДС | 1-4 | Малжуулах-1, Ахмадын эргэн төлөгдөх-1, АМЗҮ-2, ХБИАБД-1, Ажлын байрыг дэмжих төсөл-1 Нийтийг хамарсан ажилд-30 НИЙТ 36 иргэн төсөл хөтөлбөрт хамрагдсан | 90% |
| Зорилт | 2.4.1.3 | Үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа болон шинээр татварын | Даатгалд хамрагдсан ААН-ийн тоо нэмэгдсэн | Тоо | 1<br>10 | 1<br>12 | - | Жилдээ | Үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа 17 аж ахуй нэгж, байгууллагыг нийгмийн даатгалд хамруулсан. Шинээр хамрагдсан ААН, байгууллага байхгүй. | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгууллагад бүртгүүлсэн ААН-ийг нийгмийн даатгалд хамруулах | байх Сайн дурын даатгалд хамрагдсан иргэдийн тоог өмнөх онуудаас нэмэгдүүлэх | | | | | | СДД-д 184 даатгуулагч хамрагдсан.Өмнөх онтой харьцуулахад хамрагдалтын хувь 85,5% тай байна. | |
| 2.4.1.2 Зорилго Малчин, ХХЭ, ажилгүй иргэдийг Сайн дурын даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах | | | | | | | | | | |
| **Арга хэмжээ** | 2.4.1.4 | Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг иргэд даатгуулагчдад сурталчлах, үйлчилгээг цахимаар авах боломжийг бүрдүүлэх | Даатгуулагчдын "Нийгмийн даатгал"гар утасны аппликейшн хэрэглээг нэмэгдүүлэх | хувь | 10 | 20 | - | Жилдээ | Нийгмийн даатгалын үйлчилгээнүүд цахимжсантай холбогдон гар утасны апплейкшны хэрэглээ нэмэгдсэн. Эхний 11 сарын байдлаар 54 даатгуулагч иргэн тэтгэвэр тэтгэмжийн үйлчилгээг цахимаар авсан. | 90% |
| **2.5 Хүүхэд, гэр бүл, төрийн бус байгууллагын үйл ажиллагаа** | | | | | | | | | | |
| Зорилго:2.5.1 Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллах | | | | | | | | | | |
| Зорилт | 2.5.1.1 | Салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулна. | үйл ажиллагаа тогтмолжсон байх салбар зөвлөлийн тоо | Тоо | 0 | 3 | ОНТ | Жилдээ | Салбар зөвлөлүүдийн төлөвлөгөө гарган, төвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Сумын Хүүхэд хамгаалалын Хамтарсан баг нь Хүүхэд хамгаалалын 108 утсанд ирсэн 2 удаагийн дуудлагын дагуу кейс менежмент төлөвлөн 4 удаа хуралдаж кейсийг шийдвэрлэж хаасан. Эрсдэлт нөхцөлт айл өрхүүдээр эргүүл хийн ажиллаж байна. | 70% |
| Арга хэмжээ | 2.5.1.2 | Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, хүүхдээс гарсан санал санаачлагыг | Цахим орчин дахь хүүхэд хамгаалал нөлөөллийг ажлыг зохион | Хувь | 72,4 | 75 | ОНТ | 1-3-р улиралд | Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүүхдийн төлөө зөвлөлийн төвлөгөөнд тусган, хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүн Сургуулийн нийгмийн ажилтан | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дэмжих | байгуулсан байх Нөлөөллийг ажилд 6-9-р ангийн сурагчдыг бүрэн хамруулсан байх Хүүхдээс гарсан саналыг дэмжиж ажилласан байх Төлөвлөгөөний хэрэгжилт 75 -аас дээш хувьтай хэрэгжсэн байх | | | | | | Н.Уртнасан, Хэсгийн цагдаа Т.Сод-оргилтой хамтран 6-9 ангийн сурагчдад болон хүүхдийн цэцэрлэгийн ажилчдад “Цахим орчин дахь хэрэглээ” сэдэвт сургалтыг зохион байгуулан ажилласан. Хүүхдийн чуулганыг зохион байгуулж 6-9 ангийн сурагчдыг хамруулж сурагчдын саналыг сонсож, тулгамдаж буй асуудлуудын талаар ярилцаж, санал солилцон ажиллалаа. | |
| | 2.5.1.3 | Сумын хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх | Аяны хүрээнд зохион байгуулсан байх Төлөвлөгөөний хэрэгжилт 70-аас дээш хувьтай хэрэгжсэн байх | Хувь | 60 | 70 | ОНТ | 1-3-р улиралд | Сумын Хүүхдийн төлөө зөвлөлийн төлөвлөгөөг гарган, төлөвлөгөөнд тусгагдсан ажлын дагуу Дэлхийн хүүхдийн өдрөөр “Хамтдаа Хамгаалъя, шалгая” аяны хүрээнд Шилийн ирээдүй хүүхдийн чуулганаар бага ангийн сурагчдын дунд “МИНИЙ АЗ ЖАРГАЛ” сэдэвт гар зургийн уралдаан, ахлах ангийн сурагчдын дунд “ТОМЧУУДАД ИЛГЭЭХ БИДНИЙ ХҮСЭЛ” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан, Нийгмийн ардчилал залуучуудын академийн бүсийн багш Э.Даваадорж эцэг эх, асран хамгаалагч, сурагчдад “ЭХ ОРОНЧ ИРГЭН ”лекцийг, 6-9 ангийн сурагчдын санал хүсэлтийг сонсож, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх талаар харилцан санал солилцох зэрэг тус тус арга хэмжээг зохион байгуулан ажиллаж чуулганд 70 сурагч оролцсон. | 70% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.5.1.4 | Байгууллага аж ахуй нэгжийн дэргэдэх шилдэг эцэг эйиг зөвлөлийг шалгаруулах | Шилдэг эцэг эхийн зөвлөлийг шалгаруулах журмыг боловсруулсан байх. Зөвлөлүүдийн дунд 3-аас доошгүй уралдаан тэмцээнийг зохион байгуулсан байх | Тоо | 0 | 3 | ОНТ | 1-3-р улиралд | Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажилладаг. 2023 онд 3 зорилтын хүрээнд 11 ажлыг төлөвлөн ажиллаж 91%-тай хэрэгжлээ. Албан хаагчдын хүүхдийн өрөөг тохижуулах, "Миний ажил-миний гэр бүл" өдөрлөг, албан хаагчдын гэр бүлийн гишүүдийн төрсөн өдрөөр цалинтай чөлөө олгох зэрэг шинэлэг ажлуудыг зохион байгууллаа. Мөн гэр бүлийн өдрөөр албан хаагчдын гэр бүлийн хамт өдөрлөг зохион байгуулав. Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр болон шинэ жилээр албан хаагчдын хүүхдүүдийг хүлээн авч хүндэтгэл үзүүллээ. "Миний ээжийн ажлын нэг өдөр" ажлын хүрээнд албан хаагчдын хүүхдүүд ээжүүдийнхээ ажилтай танилцаж хамтдаа 1 өдрийг өнгөрүүллээ. | 70% |
| Зорилт | 2.5.2 | Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг тогтмолжуулж тэдний нийгэмд оролцох оролцоог нэмэгдүүлнэ | 2-оос доошгүй төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг тогтмолжуулсан байх | Тоо | 0 | 2 | ОНТ | 1-3-р улиралд | Эмэгтэйчүүдийн зөвлөл нь 2023 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг 3 чиглэлээр 14 ажлыг төлөвлөн хэрэгжилт 85%-тай хэрэгжлээ.Малчин эмэгтэйчүүдийн зөвлөгөөн болон Хөгжилд эмэгтэйчүүд зөвлөгөөнд нийт 7 эмэгтэйг оролцуулжлаа.Мөн малчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалтад 14 эмэгтэй хамрагдлаа.Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн үеэр баярын хурал хийж 50 эмэгтэй шинээр гишүүнчлэлийн үнэмлэхээ гардан авлаа. Мөн хайр түгээе аяныг зарлан 28 эмэгтэйг баярлууллаа.Эрхэмсэг аялгуу тоглолтыг Соёлын төвтэй хамтран зохион байгуулж МЭХ-ны хүндэт тэмдгээр 2 эмэгтэй,дурсгалын тэмдгээр | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 2 эмэгтэй шагнагдлаа .<br><br>Ахмадын хороо нь аймгийн Засаг даргын 2022 оны А/399 тоот захирамжийг хэрэгжүүлэн албан байгууллага, ААН-үүдийг хамруулж хуваарь гарган сумын ЗД -ын захирамжаар баталгаажуулан ажилласнаар сар болгоны дуулах өдрийн дуун цэнгүүний үйл ажиллагаа тогтмолжсон.Ахмадын баярыг сум орон нутагтаа Төрийн байгууллагуудтай хамтран урлаг спортын уралдаан наадам, үзэсгэлэн худалдаа, чөлөөт цагийг өнгөрүүлэх цагийн хуваарь гаргах, хүндэтгэл үзүүлэх, тэмээний өв соёлын танхим байгуулах, 3 үеийн уулзалт үйл ажиллагааг, Танд ойрхон номын сан нийт 15 үйл ажиллагааг зохион байгуулж Давхардсан тоогоор 675 ахмад хамрагдаж тэдний нийгэмд оролцох оролцоог нэмэгдүүлэн ажиллаа. | |
| Арга хэмжээ | 2.5.2.1 | Эмэгтэйчүүдийг хөгжлийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргах Төлөвлөгөөний хэрэгжилт 60-аас дээш хувьтай хэрэгжсэн байх | Хувь | 0 | 60 | ОНТ | 1-3-р улиралд | Эмэгтэйчүүдийн дэд хөтөлбөр хугацаа дууссан.Энэ онд хэрэгжээгүй | ҮБ |
| | 2.5.2.3 | Ахмадад ээлтэй байгууллага хамт олныг шалгаруулах | Шалгуур үзүүлэлтийг дагуу шалгаруулалтыг хийсэн байх | Тоо | 1 | 1 | ОНТ | 3-р улиралд | Аймгийн ахмадад ээлтэй байгууллагаар Эрүүл мэндийн төв, ЗДТГ, Хүүхдийн Цэцэрлэгийн хамт олон тус тус өргөмжлөгдсөн. 2023 оны Аймгийн ахмадад ээлтэй байгууллагаар Соёлын байгууллага, ЕБС 2-ыг оролцуулахаар болзол, шалгуур | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | үзүүлэлтийн дагуу тодорхойлолтыг холбогдох байгууллагад хүргүүлээд байна. | |
| | 2.5.2.4 | Ахмад настан хүүхэд залуучуудын 3 үеийн уулзалтыг зохион байгуулах | Тусгай удирдамжийн дагуу уулзалтыг зохион байгуулсан байх Уулзалтад 80-аас доошгүй иргэнийг хамруулсан байх | Тоо | 0 | 80 | ОНТ | 3-р улиралд | Алтан хэлхээ 3 үеийн уулзалт арга хэмжээнд клиникийн профессор Д.Эрдэнэчулуун, МУ-ын Тэргүүний ардын авъяастан, Аймгийн алдарт уяач 2-р багийн малчин С.Мөнхбат, 2022 оны Боловсролын салбарын шилдэг Төрийн албан хаагч багш Ч.Цэрэнпүрэв нар уригдан оролцлоо.Үзэгч зочиноор 6-9 ангийн сурагчид, Төрийн албан хаагчидахмадууд нийт 78 хүн оролцлоо. Уулзалтаар зочид өөрийн эзэмшсэн мэргэжил, туршлагаа хуваалцаж, үзэгч олныхоо санаа бодлыг сонсож, асуусан асуултад хариулж,эрхэм сургаалиа хайрлаж залуу хойч үедээ өвлүүлэсэн, залгамж халаагаа бататгасан, бүтээлч, онцлог ажил боллоо. | 100% |
| 3. Бэлчээрийн даац усан хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр | | | | | | | | | | |
| Зорилт | 3.1.1 | 2020онд бэлчээрийн даац 34 дахин хэтрэлттэй байгааг 2024 онд малын тоог бэлчээрийн даацад хонин толгойд шилжүүлснээр тооцож 1-2 дахин бууруулна | Бод малын өсөлтийн хувь | хувь | | 10 | 0 | Жилдээ | “Малчдын сургалт зөвлөгөөн-2023”-аар бэлчээрийн даац, малын ашиг шимийг нэмэгдүүлэх боломж, хэрэхэн хоршиж ажиллах, бод мал өсгөхийн давуу тал зэрэг сэдвээр сургалт хийгдсэн. Бод мал 1303 толгой буюу 6,9 хувиар өсч, бог мал 1721 толгой буюу 1,1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. | 70% |
| Арга хэмжээ | 3.1.2 | Бэлчээрийн менежментийн нэгдсэн төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх | Төлөвлөгөө гаргасан байх Хэрэгжилт 80-аас дээш хувьтай байх | Хувь | 0 | 80 | 0 | 1-3-р улиралд | 2023 онд 9 заалттай бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг гарган ИТХ-аар батлуулан хэрэгжүүлж байна.Төлөвлөгөөний хэрэгжилт 81 хувьтай байна. | 90% |
| | 3.1.3 | Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэн энгийн | -Ус гаргах газрыг багийн иргэдийн | Тоо | 2<br>1 | 4<br>10 | ОНХСАнН<br>92 сая | Жилдээ | Бэлчээрийн усан хангамжийг сайжруулж гүний худгийн 2 цооногийг орон нутгийн | 70% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | уурхайн худгийг засварлах, жилд инженерийн хийцтэй 2-оос доошгүй худаг шинээр гаргах | хурлаар хэлэлцүүлсэн байх -Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан байх -Шинээр худаг болон засварласан энгийн уурхайн худгийн тоо | | | | | | хөгжлийн сангийн малын тоо толгойн албан татварын санхүүжилтээр гаргахаар төлөвлөсөн. Гүйцэтгэгчээр шалгарсан Эхний эхэн ХХК-тай гэрээ байгуулсан. 1 ажлын гүйцэтгэл 50 хувьтай явж байна. энгийн уурхайн 4 худгийг засварлахаас 3 худгийг засварлаж хүлээж аваад байна. | |
| | 3.1.4 | Айл өрхүүдийг өвөлжөө хаваржааны дэргэд нөөц бэлчээртэй болгох зорилгоор хашиж хамгаалах, малын тэжээл тариалах малчдыг бодлогоор дэмжих | Малын тэжээлийн ургамал тариалах иргэдийн санал санаачлагыг дэмжих, төсөл хөтөлбөрт хамруулах Отрын бүс нутгийг тогтоох Бэлчээр хашсан өрхийн тоо | Тоо | 1 | 3 | СХСан | Жилдээ | СХС-аас 1 өрх ногоон тэжээл тариалах зорилгоор зээл аван хэрэгжүүлж байгаа. Отрын бүс нутгийг шинээр тогтоогоогүй. Бэлчээр хашсан өрх байхгүй байна. | 50% |
| | 3.1.5 | Үүлэнд нөлөөлөх засаар хур тунадасыг нэмэгдүүлэх тоног төхөөрөмжтэй болох, ажиллах мэргэжилтнийг бэлтгэх, талаар бүс нутгийн сумдтай хамтран ажиллах | Хур тунадсны хэмжээг нэмэгдүүлэхэд 1-ээс доошгүй удаа нөлөөлсөн байх | Тоо | 0 | 1 | ОНХСан 9 сая | Жилдээ | Аймгийн цаг уур орчны шинжилгээний газартай үүлэнд нөлөөлөх ажлаар хамтран ажиллах гэрээг байгуулан ажилласан. Үүлэнд нөлөөлөх ажлын зардлыг 9 сая төгрөгөөр баталсан. Цаг уур орчны шинжилгээний төвөөс үүлэнд нөлөөлөх хурын шимтэй үүл гараагүй тул тухайн үйл ажиллагааг хийгдээгүй | 70% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хүлээгдэж байна. | |
| Зорилт | 3.1.2.1 | Малын тоог чанарт шилжүүлж ашиг шимийг сайжруулах малчдын амьжиргаанд анхаарч залуу малчдыг дэмжих, малын даатгалд хамруулах замаар учирч болох болзошгүй эрсдлээс хамгаална | Төсөл хөтөлбөрт хамрагдсан малчдын тоо Малын даатгалд хамрагдсан өрхийн тоо өмнөх оноос 3 хувиар нэмэгдсэн байх | Тоо | 80 | 104 | ОНТөсөв | Жилдээ | Малжуулах төсөл хөтөлбөрт энэ онд нэг малчин өрх хамрагдаад байна. Малын даатгалд 92 малчин өрх хамрагдаад байна. | 90% |
| Арга хэмжээ | 3.1.2.2 | Илгээлтийн эзэд -3 арга хэмжээг хэрэгжүүлэх | Тусгай удирдамжийн дагуу 2-оос доошгүй айлд зохион байгуулсан байх 10-аас доошгүй залуучуудыг хамруулсан байх. | Тоо | 0 | 15 | ОНТөсөв | 3-р сард | Хэрэгжээгүй | 0% |
| | 3.1.2.3 | Амьжиргааны түвшин доогуур малчин өрхийг төсөл хөтөлбөрт хамруулах | Төсөл хөтөлбөрт 2-оос доошгүй малчин өрхийг хамруулсан байх Тусламж дэмжлэгт 10-аас доошгүй өрхийг хамруулсан байх | Тоо Тоо | 2 2 | 2 10 | ХЭДС-аас 5 сая | | 2023 онд өрх толгойлсон эмэгтэй Х.Нандинцэцэгийг 5 сая төгрөгний мал худалдан авч нийлүүлсэн. Сумын улаан загалмайн хорооноос амьжиргааны түвшингээс доогуур орлоготой 20 малчин өрхөд буцалтгүй тусламжийг олгосон. нийт 2 сая төгрөгийг зарцуулсан. | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3.1.2.3 | Дундговь тэмээ хөтөлбөрийн хүрээнд “Тэмээчдийн баяр” зохион байгуулна. | - Тэмээний баяр тэмээний соёл арга хэмжээг хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан байх<br>- Оролцсон тэмээчдийн тоо | Тоо | 0 | 40 | 3 сая Хандив | 1-р сард | Тэмээний соёл-Тэмээчдийн баяр арга хэмжээг хөтөлбрийн дагуу МУ-ын аварга тэмээчин Т.Лувсанбалдангийн нэрэмжит болгон 1 дүгээр сард зохион байгуулж атан тэмээ, торомны уралдаан, сайхан тэмээтэй хос, шилмэл хээлтэгч, хээлтүүлэгч шалгаруулах гэсэн төрлүүдээр зохион байгуулсан. нийт 31 тэмээчин оролцсон. Орон нутаг судлах музейд тэмээний өв соёлын танхимыг шинээр байгуулсан. | 90% |
| | 3.1.2.4 | “Монгол малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлэх | -Малыг үржлийн бүртгэлд бүртгэх<br>-Малын генетик нөөцийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах | Хувь | 0 | 70 | Улсын төсөв | Жилдээ | Монгол малчин 2023 оны сумын хэмжээний төлөвлөгөө болон тайланг гарган холбогдох газруудад хүргүүлэн ажиллаж байна. төлөвлөгөөний хэрэгжилт 85 хувьтай тайлагнагдсан. 2022 онд шинээр гаргасан Малын бүртгэл мэдээллийн санд 383 малчин өрхийн 166089 малыг бүртгэлд оруулсан. Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Мал аж ахуй био технологийн сургуулийн доктор, профессор н.Доржбатаар ахлуулсан ажлын хэсэг тус суманд ажиллаж Хөдөө аж ахуйн стратеги төлөвлөгөө гаргах замаар малчидтай уулзаж санал асуулгыг авсан. Мөн Бог малыг хэрхэн зөв зохистой үржил оруулах, шилэн сонголт хийх талаар зөвлөгөө мэдээлийг 2 багийн 18 малчинд хийсэн. Өндөршил омогийн адууны хээлтэгч, хээлтүүлэгчээс цусны дээж авч, үрийг хадгалах ажлыг зохион байгуулж байна. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | |  .. | |
| | 3.1.2.5 | Үндэсний үйлдвэрт арьс шир, хонь, тэмээний ноос тушаасан малчид, мал бүхий иргэдийг урамшуулалд хамруулах ажлыг үргэлжлүүлэх | Нийт 333 малчин болон мал бүхий өрхтэй. Урамшуулалд малчдыг 100 хувь хамруулах | Хувь | 70 | 100 | Улсын төсөв | 1 сард, 8 сард | РД болон дансны нэрс зөрсөн 4 өрхийн мэдээллийг засварлан аймгийн ХХААГ-т хүргүүлсэн. | 90% |
| | 3.1.2.6 | Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэнд хяналт тавих | Үржилд ашиглаж буй хуц ухныг ялган төвлөрүүлж бүртгэл мэдээллийн санд хамруулах<br>Ялган суурилж буй малчинтай гурвалсан гэрээ байгуулсан байх. | Тоо | 142 | 250 | Өөрсдийн хөрөнгөөр | Жилдээ | Сумын хэмжээнд хээлтүүлэгч бог малыг 2 баг дээр ялган суурилсан бөгөөд хээлтүүлэгч малд үзлэг ангилалтыг хийсэн. эзэмэгжүүлэлт бүртгэлд 200 ухна, 250 хуц хамрагдсан.<br><br>Хээлтийг малыг ялган маллаж буй малчидтай гурвалсан гэрээг байгуулан ажиллаж байна. Хээлтүүлэгч малын ялган суурилласан тоо өмнөх оноос 200-аар нэмэгдсэн. | 100% |
| | 3.1.2.7 | Өндөршил омгийн адууны удмын санг хамгаалах, малчдад ойлгуулах сурталчлах удам угшлын бүртгэлтэй болох | Хурд, махны чиглэлээр цэврээр үржүүлэх<br>Цөм сүргийн тоо нэмэгдсэн | Тоо | 30 | 50 | Улсын төсөв | Хавар, намар | Омгийн адуунд үзлэг ангилалт хийн малын удмын сангийн нэгдсэн бүртгэлд хамруулсан. Өндөршил түншлэл - үзэсгэлэн худалдааны үеэр өндөршил омогийн адууны шилмэл хээлтэгч, сайхан хос морьтонг шалгаруулан | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байх. Өндөршил адуунд хавар, намрын ангилалт хийх | | | | | | цахимаар сурталчилсан. Шилмэл хээлтэгч малын төрөлд 11 малчин өрхийн 18 хээлтэгч,, сайхан хос морьтны төрөлд нийт 8 малчин өрхийн 16 хос морь оролцсон. | |
| | 3.1.2.8 | Малчдад зориулсан сургалт арга хэмжээг зохион байгуулах | Малчдын зөвлөгөөнийг хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, малчдын 50 доошгүй хувийг хамруулсан байх. | Тоо | 0 | 50 | ОНХС-аас 6 сая төгрөг | Жилдээ | Аймаг сумын Засаг даргын үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу малчдын зөвлөгөөнийг 2023 оны 09 дүгээр сарын 22-23ны өдрүүдэд зохион байгууллаа. Зөвлөгөөний үеэр малчдад хэрхэн хоршооны сургалт болон бэлчээр ашигалалтын талаар сургалтыг явууллаа. нийт 112 малчин хамрагдлаа. Өндөршил түншлэлийн арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Дээрх арга хэмжээнд 7,985,000 төгрөгийг зарцуулсан.Дундговь аймагт зохион байгуулагдсан малчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалтанд 13 малчин эмэгтэйг хамруулсан. | 100% |
| 3.2 Мал эмнэлэгийн үйлчилгээний чанар хүртээмж | | | | | | | | | | |
| Зорилт | 3.2.1 | Мал амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад бүрэн хамруулж 2024 онд халдварт өвчингүй сум болно | Төлөвлөгөөт вакцинжуулалтад бүрэн хамруулсан малын эзлэх хувь<br>Гоц Халдварт өвчин гараагүй байх | Хувь | 80 | 90 | Төсөв шаардахгүй | Жилдээ | Мал амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад:<br>● Бог малын мялзан хурга-40291, ямаа-64956, ишиг-24236 хамрагдахаас хурга-26993, ишиг-11448, ямаа-60476 гүйцэтгэл 75%.<br>● Бруцеллёз тугал-300, хурга-15250, ишиг-15250 хамрагдахаас тугал-296, ишиг-6482, хурга-17556 гүйцэтгэл | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 79%.<br>● Дуут хавдар үхэр-600 хамрагдахаас үхэр-400 гүйцэтгэл 70%.<br>● ДХХ хонь-7500, ямаа-7500 хамрагдахаас хурга-1564, хонь-6717, ямаа-6646 гүйцэтгэл 99%.<br>● шөвөг яр -7000 ишиг тариглахаас 7000 хамрагдсан гүйцэтгэл 100%.<br>● сахуу- 200 унага тариглахаас 200 таригдсан гүйцэтгэл 100%.<br>● шүлхий хавар 3500 үхэр тариглахаас үхэр-3106 хамрагдаж гүйцэтгэл 89%.<br>● намар 4000 үхэр тариглахаас үхэр-3950 хамрагдаж гүйцэтгэл 99%.<br>● нийт 89%-ийн хамрагдалтай. Гоц халдварт өвчин гараагүй. | |
| Арга хэмжээ | 3.2.2 | Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэн арга хэмжээг хэрэгжүүлэх | Төлөвлөгөө гарган ажиллах<br>Төлөвлөгөний хэрэгжилт 70-аас дээш хувьтай хэрэгжсэн байх. | Хувь | 0 | 70 | Төсөв шаардахгүй | Жилдээ | Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд<br><br>● туулгалт 133013 хамрагдахаас 123264 гүйцэтгэл 93%.<br>● боловсруулалтын арга хэмжээнд 265570 хамрагдахаас 243452 хамрагдаж гүйцэтгэл 92%.<br>● гуурын боловсруулалтанд 23 үхэр хамрагдахаас 1919 үхэр хамрагдаж гүйцэтгэл 83%.<br>● угаалганд 100000 мал харагдахаас 66623 мал хамрагдаж гүйцэтгэл 66%. Бүгд 500883 хамрагдахаас 435258 хамрагдаж 87%. | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3.2.3 | Мал эмнэлэгийн нэгдсэн системийг бүрэн нэвтрүүлж мал эмнэлэгийн гэрчилгээ олгох ажиллагааг эрчимжүүлэх | Нэгдсэн системийг нэвтрүүлсэн байх. | Тоо | 0 | 50 | Төсөв шаардах гй | Жилдээ | Мал эмнэлэгийн нэгдсэн системийг бүрэн нэвтрүүлж мал эмнэлгийн гэрчилгээ нийт 1001ш бичигдэж баталгаажсан | 100% |
| 3.3 Үйлдвэрлэл үйлчилгээ, хүнс ЖДҮ-ийн чиглэлээр : | | | | | | | | | |
| Зорилт | 3.3.1 | Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгийн эс үүсвэрийг үр дүнтэй ашиглаж шинээр байнгын ажлын байрыг 20, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн тоо бүтээгдэхүүний нэр төрөл хэмжээг нэмэгдүүлж бодлогооор дэмжих замаар нутгийн брэнд бий болгоно | Брэнд бүтээгдэхүүн ий тоо нэмэгдсэн байх. Төсөлд хамрагдсан иргэний тоо | Тоо | 1 | 2 | СХСАн | 1-3-р улиралд | Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн санхүүжилтээр 3 иргэнд зээл олгож байнгын ажлын байр бий болсон. Зээлийн эргэн төлөлт хэвийн явагдаж байна. Мөн нутгийн хөрсөнд тарьсан төмс хүнсний ногоог нутгийн брэнд болгохоор санхүүгийн дэмжлэг үзүүлж ажилласан. Сумын хэмжээнд 2 аж ахуй нэгж, 11 иргэн 1,3 тн хүнсний ногооны ургац хурааж авсан. Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээлэнд хамрагдсан 1 иргэн өөрийн тариалсан бүтээгдэхүүнээрээ дундговь аймагт үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцсон. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөнгөлөлттэй зээлэнд хамрагдсан 3 иргэн өөрийн үйлдвэрлэсэн дээл, хонины элдсэн арьс, шигтгээ наамал зэргээр үзэсгэлэнд оролцсон. | 70% |
| Арга хэмжээ | 3.3.1.1 | “Өндөршил түншлэл-2023” үзэсгэлэн худалдаа зохион байгуулна | -Нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах. | Хувь | 0 | 70 | ЗД-ын нөөц | Жилдээ | Дундговь түншлэл арга хэмжээнд 2 малчин, 3 төсөл хэрэгжүүлэгч иргэн өөрсдийн үйлдвэрлэсэн хүнсний ногоо, гар урлалын бүтээгдэхүүнийг оролцуулж 1,3 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн. Өндөршил түншлэл арга хэмжээг малчдын дунд зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдаанд 11 малчин, төсөл хэрэгжүүлэгч 3 иргэн оролцсон. | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Үзэсгэлэнд орлцогч нар Цагаан идээний 8 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 1,8 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн. | |
| | 3.3.1.2 | 2023 оны тэргүүлэх чиглэлийг ИТХ-аар батлуулж хэрэгжүүлж ажиллах | Тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааны чиглэлийг ИТХ-аар батлуулж, хэрэгжүүлж ажилласан байх | Хувь | 100 | 100 | Шаардах гүй | Жилдээ | ИТХ-ын 41 дүгээр тогтоолоор тэргүүлэх чиглэлийг батлуулсан.  Тэргүүлэх чиглэлийн дагуу 3 иргэнд 70 сая төгрөгний зээлийг хоршоо хөгжүүлэх сангаас олгосон. 2023 оны тэргүүлэх чиглэлийг батлуулаагүй. | 70% |
| | 3.3.1.3 | “Хүнсний ногоо” хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 20-иос доошгүй иргэнд сургалтанд хамруулсан байх | Тоо | 10 | 20 | ОНТ | Жилдээ | Хүнсний ногоо хөтөлбөрийн хүрээнд 1 иргэнд хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээлийг олгосон. Эко-Хүнс төсөл амжилттай хэрэгжиж байна. Сургалтад ногоо тариалж буй 2 иргэний хамруулсан. | 50% |
| | 3.3.1.4 | ЖДҮ-ийн зориулалтаар олгож байгаа зээлийн уялдаа холбоог сайжруулах | Зээлийн талаарх мэдээ тайланг улирал тутам гарган | Тоо | 0 | 4 | ОНТ | Жилдээ | Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн мэдээллийн программд зээлийн мэдээллийг бүрэн оруулж сар бүр эргэн төлөлтийн мэдээг шивж, монгол банкны мэдээллийн санд илгээж байна. Хоршоо | 70% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжилтэд хяналт тавих | холбогдох газар хүргүүлэх | | | | | | хөгжүүлэх сангийн зээлийн мэдээллийн талаарх тайлан мэдээг Сумын ИТХ-д 1 удаа тайлагнасан. | |
| | 3.3.1.5 | Ундны усны эрүүл ахуйг хангаж ажиллах | Ундны усны чанарын талаар иргэдэд мэдээлэл өгсөн байх | Тоо | 34 | 70 | ОНТ | Жилдээ | Сумын төвийн иргэдийн их хэрэглэдэг амны усны шүүлтүүрийн технологид гэмтэл гарч холбогдох байгууллагад саналыг уламжилж Асрал төвийн усанд шинээр 2 шилтүүр, хуучин 3 шүүлтүүрийн засаж тавьсан . Засварын үйл ажиллагааны зардал болох 8 сая төгрөгийг тухай байгууллагаар шийдвэрлүүлсэн. Мөн эрүүл ахуйн бүс тогтоож ундны усны эхийг хашиж хамгаалсан. 3 худгаас дээж авч шинжилгээнд хүргүүлсэн боловч цаг хугацааны алдагдалтай гэх шалтгааны улмаас шинжилгээг хүлээн аваагүй. | 70% |
| 4 Газар зохион байгуулалт төлөвлөлтийн хүрээнд : | | | | | | | | | | |
| Зорилт | 4.1 | Орон нутгийн тусгай хэрэгцээний газрыг 2024 онд 50 хувьд , иргэнд өмчлүүлэх газрыг 40 хувьд тус тус хүргэнэ | Орон тусгай хэрэгцээний газрыг тоог нэмэгдүүлсэн байх<br><br>Иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлүүлэх | Тоо | 5 | 30 | 0 | Жилдээ | Нутаг дэвсгэрийн 16 хувийг орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан. Иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргүүлсэн хүсэлтийн дагуу газар өмчлүүлж байна. Энэ жил 10 иргэнд 0,7 га газрыг өмчлүүлээд байна. | 50% |
| Арга хэмжээ | 4.1.1. | Геодизийн устсан цэгийг нөхөн сэргээх. | Устсан цэгийг сэргээсэн байх. | тоо | 0 | 1 | 2 сая | Жилдээ | Сумын хэмжээнд геодизийн 52 цэгтэй. Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас геодизийн цэгийг архивын нэгжтэй тулган үзэж устгасан эсэхэд хяналтыг хийж ажилласан. хяналтаар устгасан цэгийг тулган үзэхэд | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | байршлын зөрүүнээс үүдсэн алдааг зассан. Устсан цэг байгаагүй. | |
| | 4.1.2 | Сумын хилийн цэсийн тодруулалт хийх. | Хилийн цэсийн өөрчлөлтийг газрын кадастрын системд оруулах | тоо | 0 | 1 | 3 сая | Жилдээ | Тодруулалтыг хийлгэхээр ГХБХБГ-т хүсэлт гаргаад байна. | 70% |
| | 4.1.3 | Газар нутгийн 30 хүртэлх хувийг тусгай хэрэгцээнд авах. | Ашигт малтмал газрын тосны газрын кадастрын системд бүртгүүлэх | хувь | 0 | 20% | 0 | 1-р улиралд | 22 байршилд газар нутгийн 16 хувийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан. | 70% |
| 4.2.Ногоон хөгжлийн бидний ирээдүй | | | | | | | | | | |
| 4.2 Зорилго :Ногоон байгууламжийг нэмэгдүүлж иргэдийн тав тухтай орчинд амрах нөхцлийг бүрдүүлэх. | | | | | | | | | | |
| Зорилт | 4.2.1.1 | Шинээр 2 га хүртэлх талбайд мод тариалж ойн зурвас бий болгоно. | 2 га -аас доошгүй талбайд мод тариалсан байх Ургалт 60-аас доошгүй хувьтай ургасан байх | Хувь | 40% | 50% | 5 сая БХСан | 2-3-р улиралд | Шинээр 1 га талбайг бүрэн хашаажуулж дуусгасан. 1 талбайд 300 ширхэг модыг суулгасан. Мод усалгааны явцад 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлыг томилогдон модны усалгаа болон ургалтад хяналтыг хийсэн. нийт тарьсан модны 50 хувь нь ургасан | 70% |
| | 4.2.1.2 | Шил адууны хөшөөний энгэрт зурвас байдлаар мод тарьж ойжуулах ажлыг зохион байгуулах | Шинээр суулгац хийж мод тарьсан байх Өмнөх тарьсан моднуудыг сэргээсэн байх | Тоо | 108 | 250 | 2 сая БХСан | 2-3-р улиралд | Шил адууны хөшөөний энгэрт намрын тариалалтаар 108 хайлаас суулгаж хашаа хайсыг сэргээн засварласан. | 50% |
| | 4.2.1.3 | Ойн зурвасын зураглалыг гаргаж | Усалгааны асуудлыг | тоо | 0 | 1 | 18 сая БХСан | 2-3-р улиралд | | 50% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хашаа усалгааны системийг цогц байдлаар шийдвэрлэх | шийдвэрлэсэн байх | | | | | | Шинээр Бөхт хороололын хойд талаар ойн зурвас үүсгэхээр төлөвлөж, усалгааны системийн материал, хашаа шонг худалдан авсан. | |
| | 4.2.1.4 | Цэцэрлэгт хүрээлэнд тарьсан моднуудыг иргэдийн оролцоотой усалгаа арчилгаа хийх. | Иргэдийн татан оролцуулсан байх Гэрээгээр усалгааны ажлыг хийж гүйцэтгүүлсэн байх | Тоо | 1 | 3 | 3 сая БХСан | 2-3-р улиралд | Цэцэрлэгт хүрээлэнгийн усалгааг 4 иргэнтэй гэрээ байгуулан усалгааг тогтмол хийж ургалтын хувийг нэмэгдүүлж ажилласан. Төв цэцэрлэгт хүрээлэнд нөхөн тарилтын 500 ш жигд модыг тариалсан.. | 100% |
| **5. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ** | | | | | | | | | | |
| Зорилго: 5.1 Иргэдийн ая тухтай орчинд ажиллаж , амьдрах нөхцлийг бүрдүүлж, сумын өнгө үзэмж, дэд бүтцийг сайжруулах | | | | | | | | | | |
| Арга хэмжээ | 5.1.1.1 | Сумын төвийн шинэчлэл төслийг хэрэгжүүлэх. Энэ төслийн хүрээнд гудамж хороололыг цэгцлэх, айл өрхүүдийн 00, өнгө үзэмжийг сайжруулах, гудамжны гэрэлтүүлэг, камержуулалт, төв замуудыг сайжруулах, нэгдсэн халаалтын шугамын өргөтгөл, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зэрэг ажлуудыг хийх. | Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлэгийн өргөтгөл хийгдсэн байх Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлэг камерт урсгал засварыг хийх | тоо | 1 | 5 | ОНХС 8 сая төг | 4-9-р сард | Ерөнхий төлөвлөгөөний дагуу дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний ажлын зургийг боловсруулах санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх хүсэлтээ УИХ-ын гишүүнд уламжилсан. нийтийн эүэмшлийн гэрэлтүүлэг камерийн урсгал засварыг "Од Эс Эс" ХХК гэрээ байгуулан гүцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 80 хувьтай явна.ЭМТ-ийн гадна дулааны шугамыг сайжруулж , өргөтгөл хийгдсэн. | 70% |
| Арга хэмжээ | 5.1.1.2 | Халаалтын өргөтгөл хийх | Зураг төсөв хийлгэсэн эсэх | Тий м/үгүй | 0 | 100 100 100 | ОНХС 63 сая төг | 6-9 сар | Төв магистрал шугамаас ЭМТ хүртэлх шугамыг ОНХС-ийн 55,4 сая төг-ийн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Зарцуулсан төсөв Өргөлтгөл хийгдсэн эсэх | Тоо Тийм/үшүй | | | | | санхүүжилтээр “Лорд хаус” ХХК гүйцэтгэж хүлээлгэж өгсөн. Зураг төслийг “ОСИБ-ЗТ” ХХК-д гүйцэтгэсэн. | |
| | 5.1.1.3 | Шинээр Халуун устай болох. | Ажлын даалгаварыг боловсруулж баталгаажуулан зураг төсөв хийлгэж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж барилгын ажлыг эхлүүлсэн эсэх | Тийм /үгүй Хувь | 0 | 1 | ОНХС 103 сая төг | 6-9 сар | “Говийн дэвшил” ХХК нийтийн халуун усны барилгыг ОН-т шилжүүлж өгсөнтэй холбогдуулан барилгын засвар, гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслийн даалгаврыг боловсруулж, холбогдох тех-ийн нөхцлүүдийг авч зураг төслийг “ММ инженеринг “ ХХК-иар хийлгэсэн. Төсөвт өртөг 206,720,780 -өөс 50 хувийг АОНХС-аас шийдвэрлэсэн. Гүйцэтгэгчээр “Лорд хаус” ХХК шалгарч ажлыг гйцэтгэж дууссан. Цэвэр усны худгийн ундаргыг шавхалт хийж цэвэршүүлэх ажлаас шалтгаалан ашиглалт хүлээгдэж байна. | 100% |
| | 5.1.1.4 | ЭМТ-ийн барилгад мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулж, 10 ортой эмнэлэгийг шинээр арих | Хөрсний гиологи, суурийн судалгааг хийж ЭМЯ-ны нэгдсэн зураг төсөвт холболт хийлгэсэн эсэх 2023 оны Улсын төсөвт суулгах, холбогдох байгууллагуудад хүсэлт уламжлах. | Тийм/үгүй | 0 | 1 | Улсын төсөв 3.1 тэрбум | 4-10 сар | ЭМТ-ийн шинэ барилгыг нэг загварын зураг төслөөр шийдвэрлүүлэхээр ЭМЯ-аас зураг төслийг сонгож авсан. Холболтын зургийн санхүүжилт ЭМЯ-нд батлагдсантай уялдуулан хөрсний геологийн дүгнэлт, байршлын зураг, тех-ийн нөхцлүүд, ажлын даалгавар зэргийг хүргүүлсэн хэдий ч улсын төсөвт суугаагүй байна. | 70% |
| | 5.1.1.5 | 240 хүний суудалтай соёл, спортын | 2023 оны Улсын төсөвт суулгах, | Хувь | 0 | 1 | Улсын төсөв 2.8 тэрбум | 4-10 сар | Өндөршил суманд шинээр баригдах соёл урлагийн цогцолбор нь 500 000 | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | цогцолборыг шинээр барьж ашиглалтад оруулах. | холбогдох байгууллагууд дад хүсэлт уламжлах. | | | | төг | | төгрөг 2024 оны Улсын төсөвт суугдан батлагдлаа.Мөн Барилгын зураг төсөв, Барилгын хөгжлийн төвөөр орсон магадлал дүгнэлт, Архитектурын төлөвлөгөөт даалгавар, Газрын гэрчилгээ, техникийн нөхцлүүд гэсэн баримт бичгүүдийг бүрдүүлэн Аймгийн СУГ болон яаманд хүргүүлэн ажиллаа. | |
| | 5.1.1.6 | Ашиглалтгүй байгаа хувийн хэвшлийн болон төрийн өмчлөлийн барилгуудыг өнгө үзэмжийг сайжуулах засвар үйлчилгээ хийх, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн буулгах арга хэмжээ авах. | ЗДТГ-ын хуучин зочид буудлын барилга 320 хүүхдийн хичээлийн хуучин байр, 75 хүүхдийн дотуур барилгыг мэргэжилийн байгууллагын үзлэгт оруулж дүгнэлт гаргуулах. | Тоо | 0 | 2 | 0 | 4 сар | ЗДТГ-ын хуучин зочид буудлын барилга, хуучин дотуур байрны барилгыг буулгах шийдвэр гарсан. Хэрэгжүүлэх арга замын судалгаа хийгдэж байна. | 70% |
| | 5.1.1.7 | Хүүхдийн тоглоомын талбайг орчин үеийн шаардлагад нийцүүлэн үе шаттайгаар тохижуулах | ЕБСургуулийн гадна хашааг шинээр хийх Хүүхдийн талбайн тохижилтын ажлыг дуусгаж, хүүхдийн спорт тоглоомын төв талбайг сайжруулан тохижуулна. | Хувь | 70 | 100 | ОНХС 60 сая төг | 9 сар | ЕБС-ийн гадна хашааг шинэчлэх ажил ОНХС-аар хэрэгжүүлэх ажлын жагсаалтанд нэмэлтээр орж 38,5 сая төг батлагдсан. Ажлын даалгаврыг захиалагч байгууллагын санал дээр тулгуурлан боловсруулж , гүйцэтгэгчээр “Мандал хаалга” ХХК шалгаран ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байна. “Спорт тоглоомын талбай”-н гүйцэтгэгч “Итгэлт төмөр хэлхээ” ХХК ажил гүйцэтгэх гэрээний хугацаанд өөрчлөлт оруулсан хэдий ч ажил хийгдээгүй. Тус ААН-ийн асуудлыг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр хүсэлтээ хүргүүлээд байна. | 50% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | байна. | |
| | 5.1.1.8 | Шинээр баяр наадмын талбайн асар барих | Шинэ асартай болсон эсэх Зарцуулсан төсвийн хэмжээ авч | Тий м/үгүй тоо | 0<br>0 | 1<br>181,5 сая | ОНХС 60 сая төг | 4-9 сар | Ажлын даалгаврыг барих талбайн нөхцөл байдалтай уялдуулан боловсруулж батлуулан , зураг төслийг ММ инженеринг ХХК-иар хийлгэсэн бөгөөд гүйцэтгэгчээр Хангда ХХК шалгаран 176,229,550 төг-өөр гүйцэтгэж хүлээлгэж өгсөн | 100% |

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ЗДТГ-ЫН ДАРГА Б.АМГАЛАНЖАРГАЛ

ХЯНСАН:

ЗАСАГ ДАРГА У.АЛТАНХҮҮ

**СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН**

**2023.11.25** **БӨХТ**

| Д/д | | Зорилт, арга хэмжээний тоо | Үнэлэх боломжгүй заалтын тоо | 100 | 90- | 70 | 50 | 30 | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сайн засаглалын бодлого | | | | | | | | | |
| 1 | Зорилт | 5 | - | 2 | - | 2 | 1 | | 78% |
| | Арга хэмжээ | 11 | - | 6 | 4 | 1 | - | -- | 93,6% |
| Эрүүл мэндээ дээдлэгч - Өндөршилчүүд | | | | | | | | | |
| 2 | Зорилт | 4 | - | 4 | - | - | - | - | 100% |
| | Арга хэмжээ | 13 | - | 11 | 2 | | - | - | 98.4% |
| Оюунлаг-Өндөршилчүүд | | | | | | | | | |
| 3 | Зорилт | 11 | 1 | 6 | 1 | 3 | - | - | 90% |
| | Арга хэмжээ | 28 | 1 | 19 | 6 | 1 | 1 | - | 94.8% |
| Өв соёлын өлгий - Өндөршил | | | | | | | | | |
| 4 | Зорилт | 5 | - | 5 | | - | - | - | 100% |
| | Арга хэмжээ | 22 | - | 20 | 1 | - | 1 | - | 97.2% |
| Хөдөлмөр, нийгмийн хамгаалал | | | | | | | | | |
| 5 | Зорилт | 2 | - | - | 2 | - | - | - | 90% |
| | Арга хэмжээ | 2 | - | - | 2 | - | - | - | 90% |
| Хүүхэд, гэр бүл, төрийн бус байгууллагын үйл ажиллагаа | | | | | | | | | |
| 6 | Зорилт | 2 | - | 1 | - | 1 | - | - | 80% |
| | Арга хэмжээ | 5 | 2 | 1 | 2 | 1 | - | - | 86% |
| Бэлчээрийн даац, усан хангамж | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Зорилт | 2 | - | - | 2 | 2 | 1 | - | 74% |
| | Арга хэмжээ | 22 | 1 | 5 | 6 | 8 | 2 | - | 80.9% |
| | Ногоон хөгжил – Бидний ирээдүй | | | | | | | | |
| 8 | Зорилт | 1 | - | - | | 1 | - | - | 70% |
| | Арга хэмжээ | 3 | - | 1 | | - | 2 | - | 66,6% |
| | Дэд бүтцийн хөгжил | | | | | | | | |
| 8 | Арга хэмжээ | 8 | - | 4 | - | 3 | 1 | - | 82,5 |
| | Нийт дүн | | | | | | | | |
| 9 | Зорилтын тоо | 34 | 1 | 18 | 5 | 8 | 2 | | 88.1% |
| | Арга хэмжээ | 117 | 2 | 76 | 20 | 14 | 5 | | 92.4% |
| 90.2хувь | | | | | | | | | |

ХЭРЭГЖИЛТИЙГ НЭГТГЭСЭН:

ЗДТГ-ЫН ДАРГА Б.АМГАЛАНЖАРГАЛ

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГА У.АЛТАНХҮҮ